

Зам, Тээвэр, Барилга,  
Хот Байгуулалтын сайд



/Д.Дашдорж/

МАОЭНХ-ны итгэмжлэгдсэн  
төлөөлөгч:

Монголын Барилгачдын  
Холбооны ерөнхийлөгч



/М.Батбаатар/

Монголын Барилгачдын  
Үйлдвэрчний Эвлэлүүдийн  
Холбооны дарга



УЛСНЫ БАРИЛГАНЫ  
ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛҮҮДИЙН  
ХОЛБОО  
УЗН0324Х 156618  
УЛААНБААТАР ХОТ  
/Б.Батцогт/

## БАРИЛГЫН САЛБАРЫН 2012-2014 ОНЫ ХАМТЫН ТАРИФЫН / ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү хамтын хэлэлцээр нь Монгол Улсын хууль тогтоомжинд нийцэж байгаа тул  
2012 оны 04 дүгээр сарын 13 өдөр бүртгэв.

Хамтын хэлэлцээрийг  
бүртгэв. № 07

УЛААНБААТАР ХОТ  
2012 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13 ӨДӨР

## **Барилгын салбарын 2012-2014 оны хамтын /тарифын/ хэлэлцээр**

### **Нийтлэг үндэслэл**

Монгол Улсын "Хөдөлмөрийн тухай" хуулийн II бүлгийн 19 дүгээр зүйлийн 19.1.5, 20 дугаар зүйлийн 20.4.2-ийг үндэслэн Зам, Тээвэр, Барилга, Хот Байгуулалтын сайдын 2012 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 31 дугаар тушаал, Монголын Барилгачдын Үйлдвэрчний Эвлэлүүдийн холбооны тэргүүлэгчдийн 2011 оны 06- дугаар сарын 26-ны 15 дугаар тогтоол, Монголын Ажил олгогч Эздийн нэгдсэн холбооны 2012 оны 3 дугаар сарын 29-ны 01/98 дугаар тогтоолоор тус тус эрх олгогдсон төлөөлөгчид барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарын хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын эрх ашгийг хамгаалж, салбарын болон нийгмийн хамгааллын тулгамдсан асуудлуудыг үе шаттайгаар шийдвэрлэх талаар харилцан тохиролцож энэхүү хамтын /тарифын/ хэлэлцээрийг байгуулав.

### **Ерөнхий зүйл**

Хамтын /тарифын/ хэлэлцээрийн зорилго нь хэлэлцээрийн заалтуудыг биелүүлэх замаар барилгын салбарын хөгжлийг хангаж аж ахуйн нэгжүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэхийн төлөө ЗТБХБЯам, салбарын агентлагууд, ТББ-ууд мэргэжлийн холбоод хуулийн хүрээнд бодлого, шийдвэрээрээ дэмжиж ажиллах тул энэхүү хэлэлцээрийг үндэслэн барилгын салбарын бүх аж ахуйн нэгж байгууллагууд хамтын гэрээ байгуулан ажиллана.

### **Нэг. Барилгын салбарыг хөгжүүлэх чиглэлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар:**

1.1. "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр болон "100 мянган айлын орон сууц барих"-ыг хэрэгжүүлэхэд оролцогч барилгын салбарын төрийн захиргааны байгууллагууд болон мэргэжлийн холбоод ,хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлүүд хамтран "Барилгын салбарын удирдах ажилтны 2012 оны зөвлөгөөн"-өөр барилгын салбарын хөгжлийн чиглэлээр тулгамдсан асуудлууд болон хэрэгжүүлэх арга замаа тодорхойлон гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх талаар талууд төлөвлөгөө гарган хамтран ажиллана.

1.2. Барилгын салбарын удирдах ажилтны 2012 оны зөвлөгөөний шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө нь энэхүү хэлэлцээрийн салшгүй хэсэг болно.

1.3. Монгол Улсын Засгийн газрын "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр "100 мянган айлын орон сууц" төслийн төлөвлөлт зохион байгуулалтын болон хэрэгжүүлэх арга хэмжээнд барилгын салбарт үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоог өргөнөөр хангах болон үндэсний байгууллагуудын хоршин ажиллах бүхий л хэлбэрийг дэмжин ажиллана.

1.4 Барилгын салбарын 2012-2014 оны хамтын хэлэлцээрийн хэрэгжилтэнд нь хяналт тавих үүрэг бүхий хэлэлцээрт оролцогч талуудын хамтарсан зөвлөлийг Зам Тээвэр Барилга Хот Байгуулалтын сайдын дэргэд байгуулан 2012 оны 2-р улирлаас эхлэн ажиллуулна.



1.5 Барилгын салбарт үйл ажиллагаа эрхлэж буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр мэргэжлийн холбоод, ТББ-ууд гишүүдийнхээ дунд идэвхитэй үйл ажиллагаа хэрэгжүүлнэ.

### **Хоёр. Хөдөлмөр эрхлэлтийн талаар:**

2.1. Барилгын салбарын эрэлт хэрэгцээнд нийцэх мэргэшил, ур чадвартай үндэсний ажиллах хүч бэлтгэх чиглэлээр төр хувийн хэвшлийн оролцоо бүхий Мэргэжлийн Боловсрол Сургалтын Үндэсний зөвлөлийн дэргэдэх " **Барилга, замын салбарын зөвлөл**"-ийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж дэд зөвлөлүүдийн ажиллагааг өргөжүүлэхийн тулд "**Мэргэжлийн боловсролыг дэмжих сан**"-г барилгын салбарын аж ахуйн нэгжүүдийн дэмжлэгтэйгээр байгуулж ажиллуулна.

2.2. Барилгын салбарт шинээр ажлын байр бий болгох чиглэлээр идэвхи санаачлагатай ажиллаж байгаа үндэсний аж ахуйн нэгжийн ажил олгогч эзэд, хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллана.

2.3. Барилга угсралтын ажилд болон барилгын материалын чанарт тавих хяналтыг сайжруулах чиглэлээр лабораторууд байгуулах талаар талууд хамтран ажиллана.

2.4. Тэргүүний дэвшилтэд өндөр технологи бүхий барилгын материалын үйлдвэрлэлийн жижиг дунд үйлдвэр байгуулах санаачлагыг өрнүүлэх, ажлын байр шинээр бий болгох асуудлыг дэмжиж ажиллана.

2.5 Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2012-2013 оны хэлэлцээрийн 3.7-д тусгагдсан" Хүн амын бага дунд орологотой иргэдийг хямд төсөр орон сууцаар хангах, дотооддоо үйлдвэрлэдэггүй барилгын материалуудыг дундын зуучлалгүйгээр нийлүүлэх асуудлыг судлаж шийдвэрлэнэ" гэсний дагуу талууд "**Барилгын материалын бөөний сүлжээ**" төслийг дэмжиж хамтран ажиллана.

2.6 Барилгын салбарын тендерийн хороодод салбарын мэргэжлийн холбоодын төлөөллийг бий болгож, хяналт тавихад талууд хамтран ажиллана.

2.7 Барилгын салбарын мэргэжилтэй ажилтны мэргэжлийн түвшин тогтоож зэрэг олгох үйл ажиллагааг ЗТБХБ-ын сайдын 2011 оны 273-р тушаалийн дагуу талууд хамтран 2012 оны II улирлаас хэрэгжүүлж ажиллана.

2.8 Барилгын салбарын байгууллагуудад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэргжилтийн талаар сургалт, үзлэг шалгалтыг үе шаттайгаар хийж, үйлдвэрлэлийн осол гаргаагүй аж ахуйн нэгж байгууллага болон хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажлыг үлгэр жишээ зохион байгуулж хэвшүүлсэн ажилтнуудыг "**Барилгачдын баяр**" болон "**Шинэ жилийн цэнгүүн**"-ний үеэр 3тал хамтран төлөөллийн байгууллагуудын өргөмжлөл шагналаар шагнаж урамшуулах, туршлагыг нь хэвлэл мэдээлэлийн хэрэгслээр сурталчлах, үзүүлэх сургалт зохион байгуулах талаар хамтарсан журам боловсруулж хэрэгжүүлнэ.

2.9 Барилгын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн удирдах зөвлөлд ҮЭ-ийн болон Ажил олгогчдын төлөөллийг оруулах талаар МБСҮЗөвлөлтэй хамтран ажиллана.

## Гурав. Цалин хөлсний талаар:

3.1 Барилгын салбарт ажиллагсадын үндсэн цалинг нэмэгдүүлэх асуудлыг аж ахуйн нэгж байгууллагууд хамтын гэрээгээр зохицуулахдаа дараах чиглэлийг баримтлана.

3.1.1 ЗТБХБЯамны сайдын 2009 оны 263-р "Тариф цалингийн жишиг шинэчлэн батлах тухай" тушаалын "барилгын салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтнуудын барилгын төсөвт өртөгт тусгагдсан цалингийн эх үүсвэр нэмэгдсэнтэй холбогдуулан барилгын мэргэжилтэй ажилчдыг 3-р зэргийн, туслах ажилчдыг 1-р зэргийн хийснээрх тарифт цалингийн жишгээс багагүй хэмжээгээр цалинжуулах" гэсэн 3-р заалтийн дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 358848 ( гурван зуун тавин найман мянга найман зуун дөчин найман ) төгрөг байх ба хэрэгжилтийн байдалд жилд хоёроос доошгүй удаа дүгнэлт судалгаа хийж хэрэгжилтэнд нь талууд хяналт тавьж ажиллана.

### 3.1.2 Барилгын салбарын мэргэжлийн зэрэг, түүний итгэлцүүр

№	Үзүүлэлтүүд	Мэргэжлийн зэрэг					
		I	II	III	IV	V	VI
1	Итгэлцүүр	1.00	1.11	1.25	1.44	1.66	1.92

### 3.1.3 Барилгын ажилчдын цагийн тарифт цалингийн жишиг

2	Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажилладаг	Мэргэжлийн зэрэг	I	II	III	IV	V	VI
		Цагаар хөлс авагчид	1930	2142	2413	2780	3204	3705
Хийснээр хөлс авагчид	2136	2371	2670	3076	3546	4101		

3.1.4 Хөдөлмөрийн хэвийн бус / хүнд хортой / нөхцөлд ажилладаг ажилчдын цагийн тарифт цалинг 10,8 хувиар өсгөнө.



3.2 Барилгын салбарын аж ахуйн нэгжүүдэд ажиллагсадын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн байдалд хамтарсан үзлэг хийж, нийгмийн асуудлыг шийдвэрлэж тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх, ажиллагсдаа **"100 мянган айлын орон сууц"** төсөлд хамруулах талаар санаачлага гарган ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдийг тодруулан орон сууцны урт хугацааны зээлэнд хамруулах хүн амын болон ашгийн татварын хөнгөлөлт чөлөөлөлтөнд хамруулах зэрэг урамшууллын арга хэмжээг талууд хамтран авах ба нийгмийн даатгалын шимтгэл, хөдөлмөр хамгаалал, амралтын цалин, барилгачдын талбай дээрхи хоол, ая тухтай байх орчин. түр барилгын болон автобус унааны зардлуудыг төсөвт ажиллах хүчний зардалд оруулж нормчлох асуудлыг шийдвэрлэнэ.

3.3 Барилгын үнэ бүрдүүлэлтийн тогтолцоог шинэчилэх, барилгын төсөв зохиох зааврыг өөрчлөх, цалин хөлсний системийг шинэчлэх ажлыг 2012 оны 2-р улиралд дуусгаж холбогдох шийдвэрийг гаргуулна.

#### **Дөрөв. Хөдөлмөр хамгаалал, нийгмийн баталгааны талаар:**

4.1 Салбарын аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнуудын дунд урлаг, спортын уулзалт, өдөрлөгийг 1 жилд нэг удаа зохион байгуулна.

4.2 ХАБЭАхуйн салбарын дэд хөтөлбөрийг боловсруулж батлуулан мөрдөж ажиллах

4.3 ХАБЭАхуйн менежментийн системийг барилгын салбарын аж ахуйн нэгж нэвтрүүлэх.

4.4 Ажил олгогч нь хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтанд хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүн, хоолоор үнэгүй хангах болон ажлын цагийг богинсгох асуудлыг хөдөлмөрийн болон хамтын гэрээгээр зохицуулах үүрэг хүлээнэ.

4.5 Олон улсын хөдөлмөрийн байгууллагын **"Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн орчны тухай 167-р конвенци"-ийг** судлаж 2012 онд Монгол улс нэгдэн орох саналыг боловсруулан Засгийн газарт оруулахад талууд хамтран ажиллана.

4.6 Барилгын байгуулагуудад **"Бүтээмжийн хөдөлгөөн"-ийг** өрнүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг байгууллагын бодлого бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаанд ажил олгогч, ажилтны оролцоог нэмэгдүүлэх талаар шийдвэрлэх.

4.7 Дэлхий нийтээр хэрэглэхийг хориглосон барилгын материалын импорт, хэрэглээний талаар судалгаа хийж мэдээллийн сан байгуулан нийтэд мэдээлэх ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулна.

4.8 Барилгын салбарын удирдах ажилтан, ажиллагсдын дунд хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн болон барилгын салбарын үйл ажиллагаатай холбогдолтой хууль тогтоомж норм нормативын мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг үе шаттайгаар гүйцэтгэх.

4.9 **"100 мянган айлын орон сууц"** төслийн хүрээнд баригдаж байгаа орон сууцны барилгын 1м<sup>2</sup> –ын өөрийн өртөг болон худалдаалах үнийн доод, дээд хязгаарыг тогтоох талаар ШӨХТГазар, МҮЭХолбоо зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж судалгаа хийх замаар барилгын салбарын үнэ бүрдүүлэлтийн тогтолцоог шинэчилнэ.



4.10 Барилгачдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор барилгачдыг орон сууцны урт хугацааны 6% хүүтэй зээлэнд хамруулах арга хэмжээг үе шаттайгаар авах

4.11 ХАБЭАхуйн талаар зохион байгуулж, хийж байгаа ажлуудыг эрчимжүүлэх, үйлдвэрлэлийн ослыг бууруулах зорилгоор **“Өндөр бүтээмжтэй, үйлдвэрлэлийн осолгүй ажиллагаа”** сэдэвт аяныг талууд хамтран зохион байгуулах.

4.12 Онцлог зарим ажлын байрны нөхцөлийн үнэлгээг ажиллолгогч мэргэжлийн байгууллагаар хийлгэж, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийг бууруулах арга хэмжээг жил бүр авна.

#### **Тав. Нийгмийн түншлэлийн талаар:**

5.1. Барилгын салбарын төрийн бус байгууллагуудыг мэргэжлийн чиглэлээр нь салбарын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхээр төлөвлөсөн ажлыг хариуцуулах замаар хамтын ажиллагааг нь дэмжиж ажиллана.

5.2. Гурван талтын зөвлөлийг ЗТБХБ-ын сайдын дэргэд байгуулан Барилгын салбарын шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлуудаар зөвлөлдөх, мэдээлэл солилцох, хамтын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлуудыг зохион байгуулна.

#### **Зургаа. Хэлэлцээрийг биелүүлэх талаар:**

6.1. Хэлэлцээр нь талуудын гарын үсэг зурж, эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн 2 жилийн хугацаанд хүчинтэй.

6.2. Хэлэлцээрт талуудын харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг энэхүү хэлэлцээрийг байгуулахад баримталсан журмын дагуу шийдвэрлэнэ.

6.3. Хамтын хэлэлцээрийн биелэлтийн явцыг жилд хоёр удаа ЗТБХБЯ-ны хэмжээнд дүгнэх бөгөөд талуудын төлөөлөлийн хамтарсан хурлаар хэлэлцэж хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч байна.

6.4 Салбарын хэлэлцээрийн биелэлтийг хангах зорилгоор улирал бүр төлөвлөгөөний биелэлтийг гарган нийгмийн хөдөлмөр зөвшлийн гурван талт хэлэлцээрийн төлөөлөлд тайлагнаж байна.

6.5 Цалин хөлс, нийгмийн хамгаалалтай холбоотой энэхүү хэлэлцээрээр тогтоосон доод хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг тухайн байгууллага хамтын гэрээгээр зохицуулна.

6.6 Салбарын ажиллагсдын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нийгмийн хамгаалал, болон салбарын хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийн байдалд талууд хамтарсан удирдамжийн дагуу үзлэг, шалгалт явуулна.

6.7 Энэхүү хэлэлцээр нь дараагийн хэлэлцээр байгуулагдах хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

6.8 ЗТБХБЯам, МБХолбоо, МБҮЭ-үүдийн холбооны бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөх, шинэчлэгдэх нь энэхүү хэлэлцээр дуусгавар болох үндэслэл болохгүй бөгөөд тэдгээрийг залгамжлагчид нь хэлэлцээрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

ЗТБХБЯамны сайдын  
2012 оны 01 дүгээр сарын 31-ний  
өдрийн 31 дугаар тушаалаар эрх  
олгогдсон төрийн байгууллагын  
төлөөлөгчид:

Монголын Ажил олгогч эздийн  
нэгсэн холбооны 2012 оны  
02-р сарын 10-ны 2012/ 001  
тоотой эрх олгогдсон  
барилгын салбарын ТББ-уудын  
төлөөлөгчид:

Монголын Барилгачдын ҮЭ-үүдийн холбооны  
тэргүүлэгчдийн 2011 оны 06 дугаар сарын  
26-ны өдрийн 15 тоот тогтоолоор эрх  
олгогдсон салбарын төлөөлөгчид:

УТНХЗ242 1068218

УЛААНБААТАР ХОТ

1. Төрийн нарийн бичгийн дарга

Ж.Бат-Эрдэнэ

2. БОСНААБГ-ын дарга

Б.Баасан

3. ГХБГЗЗГазрын дарга

Ц.Ганхүү

4. ХБГХБГазрын дарга

Д.Мөнхбаатар

1. БХҮНТөийн захирал

М.Цэлмэг

2. МЭТЭХолбооны дарга

Г.Мягмар

3. МБМУХолбооны ерөнхий инженер

Н.Оч

4. Хурд ХХК-ний захирал

Б.Энхжаргал

1. Салбарын ҮЭ-ийн холбооны  
нарийн бичгийн дарга

О.Батсуурь

2. Хөтөлийн ЦШХК-ний ҮЭ-ийн  
хорооны дарга,

Н.Хишигжаргал

3. МБҮЭХолбооны тэргүүлэгч

Р.Элбэгбаян

4. Байгууламж ХК-ний  
ҮЭХорооны дарга

Н.Мөнхбаясгалан

5. Санхүү хөрөнгө оруулалтын  
Газрын дарга

Г.Мөнхбилэг

5. Улаанбаатар ХХК-ний захирал

Б.Жүгдэр

5. МБҮЭХолбооны тэргүүлэгч

Д.Төгсбаяр

6. ХШҮГазрын ахлах мэргэжилтэн

Л.Болд

6. Чулуун-Өргөө ХХК-ний захирал

Ү.Банди

6. МБҮЭХолбооны тэргүүлэгч

А.Оюун

7. БОСНААБ-ын газрын мэргэжилтэн

Д.Нямдэлгэр